



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 01629

Улаанбаатар хот

М.Мөнх-Одод сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.1, 48.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.4, 10.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Мөнхбатын Мөнх-Од хууль, тогтоомжид заасан үүргээ биелүүлээгүй нь Хяналт шалгалтын газрын 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн илтгэх хуудас, өөрийн тайлбар бусад нотлох баримтаар тогтоогдсон тул түүнд 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Мөнхбатын Мөнх-Одод үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /П.Мөнхбаатар/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142304373